



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 506

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.4, дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Засгийн газрын хэвлэх үйлдвэрийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, засаж сэлбэн ашиглах боломжгүй 7 нэрийн, нийт 79,550,080.27 (далан есөн сая таван зуун тавин мянга наян төгрөг хорин долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Засгийн газрын хэвлэх үйлдвэрийн дарга Б.Отгонбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Акталж данснаас хасах хөрөнгөөс хаягдал төмрийг ялган тоолж, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” төрийн өмчит хувьцаат компанийн Улаанбаатар дахь салбарт тушаах;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001658

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн
308 дугаар тогтоолын хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭВЛЭХ ҮЙЛДВЭРИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэмжээ (ширхэг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Факсын аппарат, Panasonic КХ-FT933	12/31/2008	Ширхэг	181,728.00	1	181,728.00	0
2	Хувилагч машин, принтер Ricop МРС2030	8/8/2014	Ширхэг	6,200,000.00	1	6,200,000.00	0
3	Наагч машин	12/31/2008	Ширхэг	10,236,840.00	1	10,236,840.00	0
4	Кардон огтлогч, КР-3	12/31/2008	Ширхэг	874,500.00	1	874,500.00	0
5	Хэвлэлийн машин /Хамада Япон/	12/31/2008	Ширхэг	42,918,490.00	1	42,918,490.00	0
6	Хавтас хийгч машин, РВ-280	12/31/2012	Ширхэг	1,439,545.00	1	1,439,545.00	0
7	Офсет хэвлэлийн машин	9/10/2010	Ширхэг	17,698,977.27	1	17,698,977.27	0
Нийт дүн					7	79,550,080.27	
						(далан есөн сая таван зуун тавин мянга наян төгрөг хорин долоон мөнгө)	